



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 17 өдөр

Дугаар 1/385

Улаанбаатар хот

### Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанаас эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/423 дугаар захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй хавсралтад заасан нийт 45,872,500.00 (дөчин таван сая найман зуун далан хоёр мянга таван зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ, “Улаанбаатар театр” ОНӨТҮГ-уудын балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (Б.Батбямба)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ (Ч.Хувьзаяа), “Улаанбаатар театр” ОНӨТҮГ (Ю.Гэрэлбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150521159

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
даргын 2024 оны дугаар сарын 17-ны  
өдрийн дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба

| №                          | Хөрөнгийн нэр                   | Ашиглалта<br>д орсон он | Хэмжих<br>нэгж | Тоо<br>ширхэг | Нэгжийн үнэ  | Нийт үнэ      | Хуримтлагдсан<br>элэгдэл | Үлдэгдэл өртөг | Шилжүүлэх<br>байгууллага                                        | Шилжүүлэн<br>авах<br>байгууллага                   |
|----------------------------|---------------------------------|-------------------------|----------------|---------------|--------------|---------------|--------------------------|----------------|-----------------------------------------------------------------|----------------------------------------------------|
| 1                          | 2                               | 3                       | 4              | 5             | 6            | 7             | 8                        | 9              | 10                                                              | 11                                                 |
| Тавилга аж ахуйн эд хогшил |                                 |                         |                |               |              |               |                          |                |                                                                 |                                                    |
| 1                          | Прожектор Laser<br>цагаан       | 2019                    | ш              | 2             | 6,400,000.00 | 12,800,000.00 | 12,800,000.00            | -              | Нийслэлийн<br>иргэдийн<br>Төлөөлөгчдийн<br>Хурлын Ажлын<br>алба | "Замын<br>хөдөлгөөний<br>удирдлагын<br>төв" ОНӨТҮГ |
| 2                          | Прожекторын<br>дэлгэц 200 fixed | 2019                    | ш              | 2             | 1,500,000.00 | 3,000,000.00  | 3,000,000.00             | -              |                                                                 |                                                    |
| 3                          | Прожекторын<br>хананы төхөөрөмж | 2019                    | ш              | 2             | 250,000.00   | 500,000.00    | 500,000.00               | -              |                                                                 |                                                    |
| 4                          | Эйр кондиционер                 | 2012                    | ш              | 4             | 4,903,125.00 | 19,612,500.00 | 19,612,500.00            | -              |                                                                 |                                                    |
| Хөрөнгийн дүн              |                                 |                         |                | 10            |              | 35,912,500.00 | 35,912,500.00            | -              |                                                                 |                                                    |
| 5                          | Сандал                          | 2019                    | ш              | 60            | 166,000.00   | 9,960,000.00  | 4,938,500.00             | 5,021,500.00   | Нийслэлийн<br>иргэдийн<br>Төлөөлөгчдийн<br>Хурлын Ажлын<br>алба | "Улаанбаатар<br>театр"<br>ОНӨТҮГ                   |
| Хөрөнгийн дүн              |                                 |                         |                | 60            |              | 9,960,000.00  | 4,938,500.00             | 5,021,500.00   |                                                                 |                                                    |
| Нийт дүн                   |                                 |                         |                | 70            |              | 45,872,500.00 | 40,851,000.00            | 5,021,500.00   |                                                                 |                                                    |